

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 7 ДУГААР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж 5 дугаар сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, Архангай аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар цаг үеийн ажил, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж төрийн байгууллагын удирдах ажилтнуудад холбогдох үүрэг даалгавар болон цаашид анхаарах ажлын чиглэлийг өгсөн.

Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигийн дагуу Архангай аймгийн Засаг даргын тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл хамтран төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд зохион байгуулж аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын тамгын газар зэрэг нийт 20 байгууллагын 58 албан хаагч төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөсөн.

Архангай аймаг байгуулагдсаны 98, 99 жилийн ойн баяр наадам болон сумдын баяр наадмыг 2022 оны 7 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, Төвшрүүлэх сумын 80 жилийн ой, Булган сумын 90 жилийн ой, Өгийнуур сумын 70 жилийн ойн баяр наадмыг 2022 оны 7 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд тус тус зохион байгууллаа.

Баяр наадмын амралт буюу 7 дугаар сарын 09-нээс 17-ны өдрүүдэд Архангай аймгийн Цагаан даваа/гарах/, Цагаан хаалга/орох/-ны постоор хоногт дунджаар 4000-5000 машин, нийт 32000 машин, 128000 иргэн дамжин өнгөрсөн байна.

2022 оны 6 дугаар сарын 04-ний өдрөөс 17-ны өдрийн хооронд зохион байгуулсан хөдөө аж ахуйн салбарын тооллогод нийт 6271 өрх, 86 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсанаас газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг өрх 383, аж ахуйн нэгж байгууллага 50, мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг өрх 5888, аж ахуйн нэгж байгууллага 36 бүртгэгдсэн байна.

Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогыг зохион байгуулах аймгийн комисс томилогдож, 19 сумын 171 орон нутгийн өмчит байгууллагад үзлэг тооллогын ажлыг явуулж, үзлэг тооллогын дүнг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт нэгтгэн хүргүүлэхээр тайланг боловсруулж байна.

**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд
Төсвийн орлого, татвар төлөлт**

2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 1,580,917,382.1 төгрөг төвлөрүүлэхээс 1,520,943,661.6 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 96.2 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,289,410,500.0 төгрөг төвлөрүүлэхээс 1,507,094,535.6 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 116.9 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 7803313.9 төгрөг төвлөрүүлэхээс 7120239.8 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 91.2 хувийн тус тус биелэлттэй байна.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 87922.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд 2022 онд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 126,751,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 91 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн үүнээс 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 116033.6

сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн.

Эрх шилжиж ирсэн 27 төсөл арга хэмжээнээс төсвийн тодотголоор 700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ хасагдсан. 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний тендер 2 удаа зарлагдсан, шаардлага хангасан тендер ирээгүй тул захиалагч техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулан тендерийг дахин зарласан.

2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 114,933,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 81,527,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,704,9 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх их засвараар 1,100,0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсанаас оны эхний 7 сарын байдлаар улсын төсвийн хөрөнгөөр 5,686.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 468,3 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засвараар 746,1 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн байна.

Цахим шилжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим Архангай” төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Цахим аймаг” хөтөлбөрийн төслийг боловсруулж, хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Ай Си Ти групп” ХХК-ийг шалгаруулж, гүйцэтгэгчтэй 1,4 тэрбум төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулсан.

Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний цахим шийдэл, Сургуулийн сургалтын удирдлагын цахим шийдэл, Хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын цахим шийдэл, Аймгийн орон зайн мэдээллийн систем, Тээврийн хэрэгслийн хяналтын цахим шийдэл, Автомат шалган нэвтрүүлэх шийдэл, Аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан улсын хэмжээнд 210 гаруй төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж, нийт ХУР, ДАН системээр иргэдэд 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа бөгөөд Архангай аймгийн нутгийн захиргааны 13 байгууллагын 51 үйлчилгээ цахимжиж, "e-mongolia" системд нэвтэрлээ.

Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх төслийн хүрээнд Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумдад 20 м өндөртэй харилцаа холбооны цамхаг угсарч суурилуулах, Цэнхэр, Хашаат сумдад үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга барих ажлууд хийгдэж дууссан 8, 9 дүгээр сард ашиглалтад орно.

Мөн хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Өндөр-Улаан сумын Азарга баг, Ихтамир сумын Бугат, Хөхнуур баг, Тариат сумын Алтаад багуудад холбогдох дэд бүтцийн ажлууд хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 7 сарын байдлаар нийт 1598 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 593, зөрчлийн шинжтэй 1005 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 416 буюу 26.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 7 сарын байдлаар аймгийн хэмжээнд 228 холбогдогчтой 901.1 сая төгрөгийн хохиролтой 288 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 87 буюу 30.2 хувь, холбогдогч нь 76 буюу 33.6 хувиар өссөн байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 81 буюу 28.1 хувийг хүний эрүүл мэндийн

халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 102 буюу 35.4 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, 40 буюу 13.8 хувийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, 16 буюу 5.5 хувь нь авто ослын гэмт хэрэг, 21 буюу 7.2 хувийг залилах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 7 дугаар сард 16 удаагийн аюулт үзэгдэл осол тохиолдсоны дотор объектын гал түймэр 5, иргэний хүсэлт 1, усанд осол 4, хүчтэй салхи шуурга 5, хүний гоц халдварт өвчин /ковид-19/ цар тахал 1 тус тус гарч ОБГ-ын алба хаагчид дээрх гамшиг ослоос 10 иргэний амь нас, 142,3 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсансан.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийн хийж гүйцэтгэсэн байна.

Төрсний бүртгэл – 11

Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 5

Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 1

Гэрлэсний бүртгэл - 22

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 2

Үрчилсний бүртгэл - 3

Нас барсны бүртгэл - 40

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 119

Дахин олгосон – 5

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 132 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл –18

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 15

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл –0

Худалдах худалдан авах гэрээ – 59

Бэлэглэлийн гэрээ – 9

Барьцааны эрхийн бүртгэл – 121

Өв залгамжлал – 11

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 6

Лавлагаа – 3

Бусад эрхийн бүртгэл – 4

Хууль хяналтын байгууллагад нийт 19 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 3053531 төгрөг, тэмдэгтийн хураамжид 72000 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 11159836 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Шинээр бүртгүүлсэн – 1

Өөрчлөлт – 9

Тамганы хяналтын дугаар олгосон –1 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

2022 оны их дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гарган 750-аас дээш оноо авсан 12 сурагч, тэднийг бэлтгэсэн 11 багшид аймгийн Засаг даргын шийдвэрээр 5.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.

Соёл, урлаг

7 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд "Нүүдэлчин монгол-бидний бахархал, Адууны хийморьтой Хайрхан-II" соёлын биет бус өвийн их наадмыг Архангай аймгийн Хайрхан суманд зохион байгуулсан.

Соёлын биет бус өвийн их наадмын хүрээнд "Адуучин", "Хос морьтон" тэмцээн, "Дэмбээ" наадам, шагайн харваа, хурдан морины уралдаан, үндэсний бөхийн барилдаан, жоро морины уралдаан, үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.

Архангай аймгийн Өлзийт сумын нутаг Харганын дөрвөлжин дэх Хүннүгийн хааны зуны ордон дээр баригдаж байгаа "Төв Азийн түүх соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолбор, мэдээллийн төвийн барилгын ажил, хотыг хамгаалах хашааны ажил дууссан байна.

Эрүүл мэнд

2022 оны 5 дугаар сарын 01-нээс улсын хэмжээнд эхэлсэн хүн амыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд Архангай аймагт 2022 оны 7 дугаар сарын байдлаар 18-30 насны 608, 31-45 насны 312, 46-60 насны 157, 61-ээс дээш насны 20, нийт 920 иргэн үзлэгт хамрагдсанаас эрүүл илэрсэн иргэн 446, эрсдэлтэй илэрсэн иргэн 111, өвчтэй илэрсэн иргэн 540 байна.

Илрүүлсэн өвчин эмгэгийн тухайд, эрсдэлтэй, өвчтэй илэрсэн нийт 540 иргэнээс, 47 иргэн халдварт болон шимэгчит зарим өвчин, 1 иргэн хавдар, 42 иргэн дотоод шүүрэл, бодисын солилцооны өвчин, 112 иргэн цусны эргэлтийн тогтолцооны өвчин, 1 иргэн амьсгалын тогтолцооны өвчин, 230 иргэн хоол шингээх эрхтний өвчин, 107 иргэнээс шээс бэлгийн замын тогтолцооны өвчин тус тус илэрсэн байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал

/2022.07.27-ны байдлаар/

Батлагдсан тохиолдол:

Нийт батлагдсан тохиолдол /2021-2022 он/- 17411

Үүнээс: 2022 онд – 4548

Сүүлийн 7 хоногт /өссөн дүнгээр/ батлагдсан тохиолдол – 157

Нас баралт:

Нийт нас баралт – 42

Үүнээс: 2021 онд – 39

2022 онд - 3

Түргэвчилсэн шинжилгээ:

Нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ /2021-2022 он/ - 51677

Үүнээс 2022 онд: - 8520

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 246

Үүнээс эерэг – 93

ПСР шинжилгээ:

Нийт хийсэн ПСР шинжилгээ /2021-2022 он/ - 89027

Үүнээс 2022 онд - 11515

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 247

Үүнээс эерэг – 62

Вакцинжуулалт:

1-р тунд 60782 хүн буюу 87,1 % /12-оос дээш нас/

2-р тунд 57566 хүн буюу 82,2 % /12-оос дээш нас/

3-р тунд 27226 хүн буюу 48,9 % /18-аас дээш нас/

4-р тунд 2410 хүн буюу 4,9 % /18-аас дээш нас/

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 7 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 654 иргэн бүртгэлтэй байгаагаас 304 эмэгтэй. Шинэ ажлын байр 232, үүнээс байнгын ажлын байр 187, түр ажлын байр 45 байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

"Хөдөө аж ахуйг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд 1000 орчим малчин өрхөд ногоон тэжээл тариалахад нь овьёосны үр, техникийн дэмжлэг үзүүллээ. Сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх, өвс тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 17 суманд 80 тн үрийг олгож малын тэжээлийн ургамлын тариалалт хийгдэж дууссан.

Малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор "Малчны хотноос-Эрүүл хүнс" хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ үүлдрийн 430 толгой үхрийг мэргэжлийн үржүүлэг технологийн нэгж болон эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олголоо.

Цахир суман дахь Мал эмнэлгийн хяналтын постын гадна хяналтын 2 камерыг шинэчилсэн.

Тариалалт

Архангай аймаг 2022 онд аймгийн хэмжээнд 8265 га-д үр тариа, үүнээс 7965 га-д улаанбуудай, 4100 га-д малын тэжээл, 600 га-д тосны ургамал, 275 га-д төмс, 166 га-д хүнсний ногоо, 80 га-д жимс жимсгэнэ, нийтдээ 13486 га-д тариалалт хийж 7600 га-д уринш боловсруулахаар төлөвлөснөөс 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар

улаанбуудай 10403 га-д тариалж 130%, арвай 70 га-д тариалж 70%, хошуу будаа 340 га-д тариалж 170%, тосны ургамал 995 га-д тариалж 166%, малын тэжээл 1423 га-д тариалж 35%, хүнсний ногоо 130,6 га-д тариалж 79%, төмс 232 га-д тариалж 85%, жимс, жимсгэнэ 84 га-д тариалж 105%, нийт 13757 га талбайд тариалалт хийж. нийт тариалалт 101% хувьтай байна.

Хаврын тариалалтад трактор 346, үр тариа үрлэгч 31, хүнсний ногооны үрлэгч 7, анжис 26, борной 39, бул 11, өргөн холбоо 10, сэндэчлүүр 7, бүх төрлийн сийрүүлэгч 13, хор цацагч 8, бордоо, бууц цацагч 3, 1-25 га-г услах хүчин чадал бүхий услах бороожуулагч 3, төмс, хүнсний ногооны бага оврын иж бүрдэл трактор 3, нийт 507 техник хэрэгсэл ажилласан.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

Ногоон байгууламж, мод тарих

Архангай аймаг нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 19 сумын хэмжээнд 317716 ширхэг мод, бут сөөгийг үрээр болон тарьц суулгацаар тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгэж байна. Энэ жилийн мод тарих ажлаар төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэж сайжруулан мод тарих чиглэлийг Засаг дарга нар өгч хамтран ажиллаж байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил аргагүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Мөн ойн тухай хуулийн 30 дугаар 30.2 дугаар зүйлд заасны дагуу Ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн модныхоо тоо хэмжээнээс хамааруулан ойжуулалтын ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.

2022 онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 468.0 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөснөөс ажлын гүйцэтгэл 67.8 хувьтай байна.

Ойн сангийн хортон шавьжтай тэмцэх ажил

2021 оны намрын судалгаагаар Архангай аймгийн ойн сан бүхий 15 сумын 29015 га талбайд ойн хортон шавьжтай тэмцэх ажлыг зайлшгүй явуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарснаас 2022 онд 12 сумын 13165 га талбайд ойн хортон шавьжтай тэмцэх ажилд шаардагдах 321 сая төгрөгийн зардлыг 2021, 2022 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, байгалийн нөөц ашигласны төлбөрийн давсан орлого, орон нутгийн хөгжлийн сан, малын тоо толгойд татвар ногдуулсанаас олсон орлого зэрэг эх үүсвэрээс шийдвэрлэж, тэмцлийн ажлыг бүрэн зохион байгуулж дууслаа.

Үүнээс Жаргалант суманд 400 га, Өндөр-Улаан суманд 1000 га, Тариат суманд 4890 га, Төвшрүүлэх сум 375 га, Хайрхан сум 750 га, Эрдэнэбулган сум 50 га, Хангай суманд 200 га, Хотонт суманд 800 га, Эрдэнэмандал суманд 250 га, Цэнхэр суманд 4000 га нийт 13215 га- талбайд хортон шавьжтай тэмцэх ажлыг химийн аргыг ашиглаж үүргийн шүршигч багажаар гүйцэтгэж, аймгийн хэмжээнд тэмцлийн ажлын гүйцэтгэл 100.3 хувьтай, техникийн үр дүн 81-91 хувьтай байна.

Хог хаягдлын менежмент

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/240 дүгээр тушаалыг үндэслэн усан орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор томоохон гол, нуур тойрмын ойролцоо үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, гэр буудлууд, завьчид, хүнсний худалдаа үйлчилгээ үзүүлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдэд усны нөөцийг бохирдохоос хамгаалах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж үйл ажиллагаагаа явуулах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.

Архангай аймгийн Өгийнуурын орчимд үүссэн 120 тонн орчим хогийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын ЗДТГ-тай хамтран сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт хаяж зайлуулсан. Мөн Өндөр-Улаан сумын Бэлхи багийн нутагт дахь Чулуут голын эрэг дагуу болон аялагчид ихээр очдог Зуун салаа мод орчимд шинээр үүссэн 12 тонн хог хаягдлыг багийн Засаг дарга, байгаль хамгаалагч орон нутгийн иргэдтэй хамтран цэвэрлэлээ.

Эрдэнэбулган сумын Булган хангай хороололд 5,2 га газрыг хамарсан байсан барилгын хур хог хаягдал, шороог “Цэлмэг тэр их” ХХК компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн 100 хувийн хөрөнгөөр, 25 тн-ийн даацтай 2 техник хэрэгслээр 400 гаруй удаагийн явалтаа зөөж элэгдэл гэмтэлд орсон хөрсийг цэвэрлэж хогийг төвлөрсөн хогийн цэгрүү зөөж, газрыг түрж тэгшилсэн байна.

Аялал жуулчлал

Сум тус бүрээс сайн дурын газар зүйчдийг бэлтгэн аялал жуулчлал, түүний дагалдах үйлчилгээний газруудыг дээр зураглах “Community Mappers 2022” хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар Архангай аймгийн хэмжээнд байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газрууд, зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, аялал жуулчлалын дагалдах үйлчилгээ, нийтийн бие засах газар, хог хаях цэг, худалдаа үйлчилгээ зэрэг нийт 47 төрлийн 1114 өгөгдлийг баталгаажуулсан.

Барилга, дэд бүтэц, газар

2022 оны 7 дугаар сард улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт болон их засварын ажлуудад барилга захиалагчийн хяналтыг 18 суманд хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.

2022 онд “Гост трейд” ХХК-ийн “Хангайн төгөл” эвент халл ресторан, иргэн Чилхаасүмбэрэлийн 3 давхар зочид буудал, рестораны барилга тус тус ашиглалтад орсон байна.

2022 аймгийн хэмжээнд дараах 10 орон сууц баригдаж байна. Үүнд:

1. “Гурван тамир” ХХК - Орон сууцны барилга - 5 давхар 15 айл - гүйцэтгэл 40 хувь.

2. “Мөнх өсөх өргөө” ХХК - Үйлчилгээ, орон сууцны цогцолбор барилга - 5 давхар 4 блок 120 айл - гүйцэтгэл 40 хувь.
3. Иргэн Н.Манлай - Үйлчилгээтэй орон сууцны цогцолбор хотхон - 6 давхар 4 блок 192 айл - гүйцэтгэл А блок - 80%, Б блок - 20%
4. Иргэн Б.Бямбаа - Үйлчилгээтэй орон сууцны барилга - 6 давхар 60 айл - гүйцэтгэл 80 хувь
5. “Цагаан сүмбэр” ХХК - орон сууц - 5 давхар 50 айл - гүйцэтгэл 70 хувь.
6. Иргэн Сүхбаатар - орон сууц - 4 давхар 12 айл - гүйцэтгэл 90 хувь.
7. Иргэн Б.Бямбаа - орон сууц- 5 давхар 4 блок- гүйцэтгэл А блок-10 хувь.
8. Иргэн Чулуунбаатар – Үйлчилгээтэй орон сууц - 5 давхар 18 айл - гүйцэтгэл 40 хувь.
9. “Сайхан тэрх” ХХК – Үйлчилгээтэй орон сууц - 5 давхар 23 айл - гүйцэтгэл 70 хувь.
10. Иргэн Бадралт - орон сууц - 6 давхар 30 айл - гүйцэтгэл 70 хувь.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----